



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 4/209

Мандалговь

Хөрөнгө хүлээн авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 “а”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын “Эрүүл хот- Эрүүл иргэн” дэд хөтөлбөрийн хүрээнд Нарлаг багт хийгдсэн Ариун цэврийн байгууламжийг хүлээн авах ажлын хэсгийг томилсугай.

Үүнд: Г.Буянбат / Нарлаг багийн засаг дарга /

Д.Мөнхцоож / Хот тохижуулах газрын ахлах мэргэжилтэн/

Г.Ундармаа /Хот тохижуулах газрын нярав /

2. Дээрх хөрөнгийг хүлээн авч, эд хөрөнгийн бүртгэлд тусгахыг Хот тохижуулах газрын нярав (Г.Ундармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Р.МӨНХТОГТОХ